



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1151

Шивээговь сум

Эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 78 дугаар зүйлийн 78.2.1, 80 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1, 4.1.4, 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Говьсүмбэр аймгийн Төрийн аудитын газраас өгсөн албан шаардлагын дагуу дутуу бүртгэгдсэн сумын 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар худалдан авч хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмж, бараа материалыг байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгөнд холбогдох хууль, журмын дагуу бүртгэн авахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч наарт үүрэг болгосугай.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын бараа, тоног төхөөрөмжийг хөрөнгөнд бүртгэх жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон бараа материал, тоног төхөөрөмжийг зөв зохистой хэрэглэж, өмч хамгаалалт, ашиглалтыг журмын дагуу хариуцан ашиглахыг байгууллагын нягтлан бодогч, няравуудад даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (Б.Алтансүх)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ



Сумын засаг даргын 2023 оны 04-р сарын 05-ны
өдрийн №/51... дугаар захирагчийн хавсралт

2022 оны Орон нутгийн хөгжлийн сангаар хийдсэн бараа тоног төхөөрөмж, бүртгэлжүүлэх албан байгууллагын жагсаалт

№	Төсөл арга хэмжээний нэр, хучин чадал, байршил	Хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон хөрөнгө	Тоо ширхэг	Нэг бурийн үнэ	Нийт үнэ	Төсөвт өртөг	Хөрөнгө бүртгэх байгууллагын нэр	Илчлэг шивээ ОНӨААТУГ	Ш.Чинболд	Удирдлага	
1	Алсын 1,2-р худгийг шинэчлэн засварлах						19,700,000				
2	Сургуулийн дотуур байрны засвар						16,900,000	3-р сургууль	С.Энхцэцэг		
3	Усан хантамжийн системийг алсын горимд оруулах ажил						14,941,251	Илчлэг шивээ	Ш. Чинболд		
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрөө тохижуулах	пед гэрэл	3ш	200,000	600,000						
		Ус буцаалтгач	1ш	500,000	500,000						
		Хаалганы хаяг	1ш90+50	200,000	200,000						
		Дрож	42M	50,000	2,100,000			5,000,000	ЗДТГ	Ч.Сугармаа	
		Цонхны хөшиг	2ш	400,000	800,000						
5	Сумын нийтийн эзэмшилийн инженер шугам сүлжээний цэвэр усны шугамын өргөтгөл	Ширээ	1ш	800,000	800,000						
6	Сумын төв болон гудамж талбайн гэрэлтгүүлэг нэмэх, гэрлэн чимэглэл хийх ажил						185,549,300	Илчлэг шивээ ОНӨААТУГ	Ш. Чинболд		
7	Шинээр олгогдсон өмчлөлийн газарт цахилгаан татах ажил / сэвхүүл, хороолол, урсах хороолол, 3-р цэцэрэлийн дотор гадна Цахилгааны монтаж						79,880,833	ЗДТГ	Ч.Сугармаа		
НИЙТ							151,740,131	ЗДТГ	Ч.Сугармаа		
							473,711,515.00				